

УЛС ТӨР

Д.ЭРДЭНЭБАТ: МАН ЗЭЭЛ АВАХААР ЭДИЙН ЗАСАГ ДЭЭШИЛЖ, АН АВАХААР ДАМПУУРНА ГЭЖ ЮУ БАЙХ ВЭ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ТӨРИЙН АЛБАНЫ ХУУЛЬ УЛС ТӨРИЙН ЗОРИЛГОТой ЮУ

V нүүрт

Улаанбаатар: ӨНӨӨДӨР



Дугаарын **60** мөр

ҮЗЭЛ БОДОЛ

МАН-ЫН гишүүдийн гурван

ТӨВШИН

Б.ТОГТОХ

Нэрийг нь хэлээд яах вэ, саяхан нэг улстөрч Монгол Улсын нийгэм эдийн засгийн тун чухал хуулийн төслийг УИХ-ын даргад өргөн мэдүүлжээ. Тун ч анхаарал татах сэдэв байсан учраас хэвлэл мэдээллийнхэн түүнээс энэ сэдвээр нь ярилцлага авахыг хүссэн юм байх. Гэтэл өнөөх улстөрч маань “би мэдэхгүй” гэсэн хариулт өгсөн аж. Хуулийн төслийн автор болж байгаа атлаа яагаад өргөн барьсан сэдвээ мэдэхгүй байгааг нь асуухад “Нам л өргөн барь гэсэн. Тэрнээс биш би боловсруулаагүй. Ажлын хэсэг ахлах хүн нь тайлбарлаад явна биз” гэсэн хариулт өгсөн гэх. Энэ бол болсон явдал. Бүр салбар яам толгойлж буй сайд хүний амнаас гарсан үг юм шүү.

Төгсгөл нь III нүүрт

ДОТОР НҮҮРТ




БРЭД ПИТТ: ОДОО ЭНЭ БҮХНИЙГ ӨӨРЧИЛМӨӨР БАЙНА

8

Хорвоогийн муу бүхний үүр

ТАВАНТОЛГОЙ болжээ



Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

Х.Баттулгын сонгуулийн штабыг Я.Санжмятав удирдана

Б.ӨНӨР

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль энэ сарын 26-ны өдөр болно. Харин хилийн чанадад амьдарч байгаа иргэдийн саналыг зургадугаар сарын 10-11-ны өдөр явуулахаар болсон билээ. Үүнтэй холбогдуулан нам хүчнүүд сонгуулийн бэлтгэл ажлаа хангасаар байгаа юм. Тэгвэл АН-аас Ерөнхийлөгчид нэр дэвшигч Х.Баттулгын Сонгуулийн штабын менежерээр УИХ-ын гишүүн, УИХ-ын дэд дарга Я.Санжмятав томилогджээ. Тэрбээр, Завхан нутгаас УИХ-д сууж буй бөгөөд салбар яам удирдаж байсан, УИХ-ын дэд даргын албан тушаалыг хашдаг туршлагатай улстөрч билээ.

ТОМИЛОЛТ



Ж.ТҮВШИНБАЯР:

ЭДИЙН ЗАСАГ ХҮНД ҮЕД ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА ЧУХАЛ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭДЭГ

Ч. ЧУЛУУН

Дорноговь айлгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн Гадаад харилцааны лэргэжилтэн Ж.Тувшинбаяртай манай сурвалжлагч Сайншанд хотноо уулзаж, ярилцсан байна.

-Засаг дарга Т.Энхтүвшин нэгэнтээ “Манай аймгийн хөгжил дэвшилд гадаад харилцаа чухал үүрэг гүйцэтгэж буй” хэмээн онцолсон. Үнэндээ ч эдийн засгийн хямрал үргэлжилж

буй энэ үед гаднаас хөрөнгө оруулалт татна, тэдэнтэй хамтарч ажиллана гэдэг чухал зүйл билээ? -Дорноговь өөрөө их онцлогтой аймаг. Хилийн бүс нутаг. БНХАУ-аар дамжин Монголыг зорих хэн бүхэн хамгийн түрүүнд манай аймагтай танилцдаг. Бас ёс заншил, хөгжил цэцэглэлт нь ямар вэ гэдгийг хардаг, мэддэг. Нөгөөтэйгүүр, аливаа улс орны хөгжил дэвшил дандаа гадаад харилцаан дээр тулгуурласан байх бий.

Төгсгөл нь VI-VII нүүрт

TESS
BLACK TEA COMPOSITION
FOREST DREAM
black tea, raspberry & blueberry
20 pyramid tea bags

форест ДРИМ

Цейлон байхуу цайны гайхамшигт амтыг бооролзгоно болон нэрс жимстэй хослуулсан төгс цай

Пирамид савалгаатай цайны давуу тал:

- Цайны навчны ашигтай чанарыг бүрэн хадгалдаг
- Төрөл бүрийн хатаасан жимс болон ургамал агуулдаг
- Силкен материалаар хийгдсэн уут нь цайны амтыг илүү тодотгодог

ХААН банк	Хугалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2415.00	2424.00	ФУНТ	3102.00
ЕВРО	2664.00	2726.00	РУБЛЬ	41.40
ИЕН	21.58	21.85	ЮАНЬ	349.50

УЛС ТӨР

ХААЛТАЙ ХУРАЛДААНААС

Д.ЭРДЭНЭБАТ: МАН ЗЭЭЛ АВАХААР ЭДИЙН ЗАСАГ ДЭЭШИЛЖ, АН АВАХААР ДАМПУУРНА ГЭЖ ЮУ БАЙХ ВЭ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ТОГТОХ

УИХ дахь Ардчилсан намын бүлэг өчигдөр ээлжит хурлаа хийж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Прокурорын тухай хуулийн төслийн талаар УИХ-ын гишүүн Б.Пүрэвдоржийн танилцуулгыг сонсчээ. Мөн Ерөнхийлөгч болон УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн нарын өргөн барьсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсгийн ахлагч УИХ-ын дэд дарга, УИХ-ын гишүүн Я.Санжмятавын мэдээллийг тус тус сонсчээ. Хэлэлцсэн асуудлын талаар УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Эрдэнэбат, УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж, Ажлын албаны дарга Д.Золжаргал нар мэдээлэл хийлээ. Бүлгийн хуралдааны эхэнд Төрийн албаны тухай

хуулийн төслийг ярилцаж хэтэрхий улстөржсөн, Төрийн албаны зөвлөлийг улс төрийн хараат болгох гэсэн хүснэгт хуулийн төсөл болсон гэж АН-ын бүлэг үзсэн аж. Хоёрдугаарт, УИХ-ын 30 дугаар тогтоол Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн иргэний хүсэлтэд мэдээлэл хүргүүлэх нь зөв гэж үзсэн байна. Тодруулбал, УИХ-ын 29 дүгээр тогтоолын 11 дүгээр дэд заалтыг хүчингүй болгосон асуудлаар АН-ын бүлэгт нийслэлийн Баянзүрх дүүргийн иргэн О.Алтангэрэлээс хүсэлт иржээ. Иргэн О.Алтангэрэл нь УИХурлын 29 дүгээр тогтоолын 11 дүгээр дэд заалтыг хүчингүй болгосон УИХ-ын 30 дугаар тогтоол нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзээд, Үндсэн хуулийн цэцэд мэдэгдэл гаргах гэж байгаа тухай хүсэлт ирүүлсэн аж.

Тиймээс Ардчилсан намын бүлгийн хурлаар уг асуудлыг хэлэлцээд, иргэн О.Алтангэрэлийн хүсэлтийг нь дэмжиж, нэн шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх нь зүйтэй гэж үзсэн талаар бүлгийн дарга онцлолоо. УИХ-ын 29 дүгээр тогтоолын 11 дүгээр дэд заалтын тухай Гадаадын хөрөнгө оруулалттай томоохон төслүүдийн хөрөнгө оруулалтын гэрээний үр ашгийг дээшлүүлэх, борлуулалтын орлогыг монгол дахь банкны дансаар дамжуулдаг болгож, олон улсын валютыг нэмэгдүүлэх заалт юм. Гэтэл үүнийг УИХ 30 дугаар тогтоолоороо хасах шийдвэрийг гаргасан билээ. Мөн АН-ын бүлгийн дарга Д.Эрдэнэбат Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой сүүлийн үед хэвлэл мэдээлэлээр явж буй АН-ын бодлогыг харлуулах гэсэн сөрөг пиарын талаар байр сууриа илэрхийлэв. Тэрбээр, “Эрх баригчид нэг зүйлийг л ойлгох хэрэгтэй. 2016 оны УИХ-ын сонгуулийн маргаашнаас эхлээд, монголын ард түмний хувь заяаны

тоолуур эрх баригчдын гарт тоологдож эхэлсэн. 2012-2016 онд Ардчилсан намын эрх барьж байсан үеийн бүх зүйлүүдийг харлуулж, улс төрийн ашиг хонжоо олно гэдэг байлаа одоо болж хэрэгтэй. Засгийн газрын эрхийг аваад бүтэн жилийн хугацаанд долоон төрлийн татвар нэмсэн, ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдах бэлтгэл хийсэн, хууль эрх зүйн орчинг дордуулсанаас өөр яг юу хийв гэдгээ өөрсдөө эргээд харчихаарай гэж сануулмаар байна. МАН амлалтаа биелүүлээгүй бүтэн нэг жилийг үлдээ. Нөгөө сайхан амлалтуудаасаа 100 хувь ухарчихсан. Гэтэл сүүлийн үед хэвлэл мэдээллээр “Эдийн засаг сэргэсэн, хүн амын орлого өслөө” гэдэг мэдээлэл их цацах боллоо.

Эдийн засаг 4.1 хувиар өссөн нь нүүрсний үнэ өссөн мөн долоон төрлийн татвар нэмсэнтэй холбоотой болохоос эрх баригчдын гавьяа биш. Татвар нэмээд, цалин нэмээгүй байхад иргэдийн орлого хаанаас нэмэгдээд байгаа юм гэдэгт эрх баригчид хариултаа өгөх хэрэгтэй. Одоо хоосон үзэл суртлаа зогсоогоод эдийн засгийн бодит байдал дээр иргэдийнхээ амьжиргааг сайжруулах ажлыг эхлүүлэх цаг нь аль хэдийнэ болчихсон. МАН өр тавихаар буюу 5.5 тэрбум ам.долларын зээл авахаар эдийн засаг сэргэдэг, АН 2.5 тэрбум ам.долларын зээл авахаар эдийн засаг сүйрдэг тийм мараалгүй амьжиргаагаар дүгнэгдэх болно. Бүтэн жил ард түмний амьдрал дээшлээгүй. Харин улстөрчдийн хийрхэл л дээшилсэн” хэмээн бухимдлаа. Бүлгийн хурлын мэдээллийн үеэр УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслөөр мөн байр сууриа илэрхийлэв.

ОНЦЛОХ УЛС ТӨР

ТАТВАРЫГ ЭСЭРГҮҮЦЭЖ МАШИНАА ШАТААХЫГ ЗАВДАВ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

УИХ-д ялалт байгуулахдаа татвар нэмэхгүй, халамж өгнө, ард түмний амьжиргааг дээшлүүлэн хэмээн амалсан МАН-ынхан амлалтаасаа ухарсан. Улмаар засаглах эрхээ гадныханд өгөхийн тулд долоон төрлийн татвар нэмсэн нь иргэдийн нуруунд хамгийн хүнд ачаа болж буй юм. Өргөн хэрэглээний бараа нэмэгдэж, шатахууны үнэ ч литр тутамдаа нэмэгдчихсэн байгаа. Тэр тусмаа ард түмний гол унаа болсон приус машины татварыг 100 хувь чөлөөлж байсныг 50 болгон бууруулсан нь асар их эсэргүүцэлтэй тулгарч байгаа

билээ. Тэгвэл өчигдөр энэ мэт шийдвэрийг эсэргүүцсэн иргэд Төв талбайд жагсаал хийж, машинаа шатаахыг завдлаа. Тэд “Иргэдийг ядууруулах бодлогоо зогсоо, Татвар нэмэхээ зогсоо, Сонгуулийн амлалтаа биелүүл,” хэмээн Сүхбаатарын талбайд автомашинтай эсэргүүцлийн жагсаал зохион байгуулах гэсэн боловч цагдаагийн албан хаагчид тэднийг зогсоосон юм. Жагсагчдын нэг нь приус машинаа шатаахыг завдсан ч цагдаагийн алба хаагчид таслан зогсоожээ. Улмаар Төрийн ордонг тойрон лоозон барин жагссан юм.

“Приус” машины

татвараас 100 хувь

чөлөөлөх асуудлыг тавих

болно

...Мэдээллийн дараа намын бүлгийн удирдлага болон гишүүд этгүүлчдийн сонирхсон асуудалд хариуллаа.

“Приус” машины татварыг нэмэхгүй байх асуудлаар танай намын бүлэг санал гаргаж байсан. Гэтэл Х.Нямбаатар гишүүний санаачилсан төслөөр асуудлыг хэлэлцэж эхэллээ. Энэ талаар байр сууриа илэрхийлээч?

Д.Эрдэнэбат: Эдийн засгийн амьдралыг ялангуяа иргэдтэй холбоотой амьдралын асуудлыг битгий улстөржүүлээч. Тухайлбал, “Приус” машины татварыг чөлөөлөх гэж хэлэхээр буцаагаад сөрөг пиар руу орсон. Батерий нь муу, хадгалж болдоггүй, хар тугалгатай гэхчлэн сөрөг зүйл яриад эхэлсэн. Үүнийг би Засгийн газрын зүгээс хийгээд байна уу хардаж байгаа. Д.Эрдэнэбат байна уу, Х.Нямбаатар санаачилна уу хамаагүй. Энэ ард түмэнд хэрэгтэй зүйл байсан учир Засгийн газар шийдээд оруулж ирэх хэрэгтэй. Үүнд битгий улс төрийн хандлага гаргаач ээ. Эрх баригчид асуудлыг хумхын тоосын чинээ жижиг байсан ч улстөржүүлдэг боллоо. Цаашдаа ард түмний унаа болсон “Приус” машины татварыг хойшлуулах биш татвараас 100 хувь чөлөөлөх асуудлыг тавих болно.

УИХ-ын ирц хангалтгүй байна гэдэг байр суурийг ганцхан О.Баасанхүү гишүүн хөндөж ярьж байна. Танай намын бүлэг яагаад ярихгүй байна вэ?

Д.Эрдэнэбат: Ирцийн тухайд, эрх баригчид 65 гишүүнтэй шүү дээ. Гэтэл ирцийг манай тал

руу наалдуулах юм. Энэ нам өөрийнхөө болохгүй асуудлыг заавал Ардчилсан нам руу наадаг. Чуулганы танхимд МАН-ын 15, АН-ын 4 гишүүн сууж байхад “АН-ын есөн гишүүн бүгдээрээ байх ёстой” гээд байх юм. Муу л бол хойд талын хар овоохой гэгчээр АН руу дайрч байна. Ингэхээ боль. АН руу дайрах арга хайх хооронд чинь ард түмний амьдрал хэцүүдлээ.

Ж.Энхбаяр:

Монголбанкны хохирол

олон зуун тэрбумаар

хэмжигдэж байна

УИХ дахь МАН-ын бүлгийн ээлжит хуралдаан Төрийн ордны “Б” танхимд өчигдөр бүтэн өдөржин хуралдсан ч сэтгүүлчдэд мэдээлэл хийгээгүй юм. Тэр ч байтугай намын бүлгийн ажлын хэсгийнхнээ ч оруулахгүй хаалттай байдлаар хуралджээ. УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос ажлын хэсэг байгуулагдан, төв банкны 2012-2016 оны үйл ажиллагаанд шалгалт хийсэн. Уг шалгалтын дүнг бүлэг хэлэлцсэн гэх мэдээлэл байгаа юм. Монголбанк өнгөрсөн 2013, 2014 онд “Үнэ тогтворжуулах” хөтөлбөр хэрэгжүүлсэн байдаг. Уг хөтөлбөрийн хүрээнд тодорхой компаниудад хямд эх үүсвэртэй зээл олгосон. Гэвч зарим зээлийн эргэн төлөлт хангалтгүй, тэр дундаа чанаргүй зээлийн нэлээд хэсгийг энэ төрлөөр олгосон зээл эзлэх болсон талаар өмнө нь ажлын хэсгийн гишүүн Ц.Даваасүрэн хөндөж байлаа. Тиймээс чанаргүй зээлээс эхлээд олон асуудал энэхүү хаалттай хуралдааны цаана хөндөгдсөн

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Япон улс руу төмс экспортлохоор ярьж эхэлжээ

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат өнгөрөгч ням гарагт газар тариалангийн бүс нутаг Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймагт ажиллаж, зарим аж ахуйн нэгжийн тариалалтын явцтай танилцаж, тариаланч, ногоочидтой уулзан, тэдний өмнө тулгамдсан асуудлыг сонслоо. Харин өчигдөр Булган, Орхон аймагт ажилласан юм. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат ням гарагт эхлээд Төв аймгийн Жаргалант суман нутаг дахь “Хөх баян булаг” ХХК-ийн улаан буудайн тариалалтын явцтай танилцлаа. Тус компани энэ онд 3000 га-д улаанбуудай тариаар төлөвлөсөн байна. Өнгөрөгч дөрөвдүгээр сарын 8-нд тариалалт эхэлсэн, өнөөдрийн байдлаар 93 хувьтай байгаа аж. Хүнсний ногоо, ялангуяа төмсний борлуулалтад Засгийн газар бодлогоор дэмжиж оролцох, төрийн худалдан авалт хийж ногоочид, тариаланчдаа дэмжихийг тус компанийн захирал хүсч байлаа.

Энэ асуудалд Засгийн газар анхаарч ажиллаж байгаа. Тухайлбал, Японы компаниуд монгол төмс худалдан авах захиалга ирүүлж байгаа. Одоогоор хоёр удаагийн дээж явуулсан нь тус улсын стандартад тэнцээд байгааг Ерөнхий сайд онцлов. Түүний дараагийн очсон газар бол Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Газар өгөөж” ХХК. Тус компани нийт 7300 га талбай эзэмшдэг бөгөөд энэ онд 4500 га-д нь улаан буудай тариалахад төлөвлөжээ. Одоогоор тариалалтын явц 80 гаруй хувьтай байна гэж компанийн удирдлага Ерөнхий сайдад танилцуулсан юм. Энэ уулзалтын үеэр хөндөгдсөн гол сэдэв нь хөрс арчилгааны тухай. Тариаланчид арвин ургац авахын тулд хөрсний үржил шимийг хамгаалах, сайжруулах, ноён сөргөөх нь чухал гэдгийг Ерөнхий сайд хэлж байсан юм. Харин салбар яамны сайд П.Сэргэлэн “Хөрс арчилгааны чиглэлд Монгол Улс БНХАУ-тай хамтран ажиллана. Энэ хүрээнд хөрс арчилгаа, шинжилгээний хамтарсан лаборатори байгуулахаар тохирсон” гэсэн хариулт өгсөн юм.

Эх орноосоо урвах асуудлаар ноцтой баримт дэлгэнэ гэв

УИХ-ын гишүүн О.Баасанхүү өчигдөр Төрийн ордонд хар тамхины хэргийг ялаас чөлөөлсөн гэх асуудлаар мэдээлэл хийлээ. Тэрбээр “Эрүүгийн хуульд 40 орчим заалтыг өөрчилсөн гэх нэрээр зарим зүйлийг оруулж ирсэн. Тэгсэн хэрнээ гол өөрчлөлтүүдийг оруулаагүй. Үүний нэг нь хар тамхитай холбоотой хэргийг ялаас чөлөөлчихсөн байна. Хуучин Эрүүгийн хуулийн 192, 196 гэсэн заалтаар энэ төрлийн гэмт хэргийг шийтгэж байсан бол одоо 20.7 гэсэн заалтаар энэ асуудлыг зохицуулах болж байна. Өмнө нь “мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодис” гэдэг байсан бол одоо зөвхөн “бодис” болж эм бэлдмэл нь байхгүй болсон. Мөн “борлуулах зорилгогүйгээр авч хадгалсан” тохиолдолд ял шийтгэдэг байсан бол одоо чөлөөлж байна. Үүнээс гадна Эрүүгийн хуульд доод ял 10 жил оноодог байсныг таван жил болгосон. Шүүгч үзэмжээрээ ял оноож болно гэсэн үг. Энэ мэт ноцтой өөрчлөлтүүд орсон” гэлээ. Мөн “Хар тамхи хэрэглэх байраар хангасан бол ял оноодог байсныг торгодог болголоо. Хуулиар зөвшөөрсөн мөнгө олдог гурван аймшигтай бизнес байдаг. Энэ бол архи, тамхи, эм. Үүнд хатуу хяналт хэрэгтэй. Хуулиар зөвшөөрөөгүй ч асар их ашиг орлоготой, асар их үр дагавартай, аюултай зүйл бол хар тамхи, эм, эсгийг наймаа. Аль ч улсад хар тамхины ялаа нингэж зөөлөөсөн түүх байхгүй. Өмнөх хууль ч хар тамхины хэрэгт тийм хатуу байгаагүй. Гэтэл лоббигоор улам хөнгөрүүлж, ял шийтгэлийг гурав дахин багасгалаа. Хар тамхины хэрэгт хэзээ ч ялаас чөлөөлдөггүй. Энэ хэрэг дээр хохирол шаардахаа больсон харамсч байна. Үүнийг хэлэлцэж эхлэхэд би эсэргүүцэж, байнгын хорооноос гарахаа ч илэрхийлж байсан. Гэтэл сая бараг хуралдаанаас намайг хөөж байсан. Хамгийн хатуу шийтгэх ёстой гэмт хэрэг бол хар тамхи, эх орноосоо урвасан хэрэг. Би удахгүй эх орноосоо урвасан гэмт хэргийн талаар ноцтой баримт дэлгэнэ” гэсэн юм.

ДЭЛХИЙ



ТАЙЛАНДЫН ЦЭРГИЙН ЭРГЭЛТЭЭС ХОЙШХИ ГУРВАН ЖИЛ

Б.ДАВАА

Тайландад 2014 онд цэргийн эргэлт хийснээс хойш өчигдөр гурав дахь жилийнхээ ойтой золголоо. Ерөнхий сайдын үүргийг түр орлон гүйцэтгэж буй Прают Чан Очагийн тэргүүлж буй цэргийн Засгийн газрын тогтоосон онц байдалдүгээхүртэлүргэлжилж байна. Тайландын шинэ эзэн хаан Маха Важирапонкорн өнгөрөгч дөрөвдүгээр сард шинэ Үндсэн хуульд гарын үсэг зурж баталсанаар тус улсад ардчилсан тогтолцоог нэвтрүүлэх, бүх нийтийн сонгууль болох боломж нээгдсэн юм. Эзэн хаан гарын

үсэг зурснаас хойш хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн тус хуулийн дагуу бүх нийтийн сонгууль хамгийн эртдээ гэхэд 2018 оны сүүлийн хагаст зохион байгуулагдах төлөвтэй байгаа билээ. Эдүгээ тус улсыг армийнхан голдуу гишүүдээс бүрдэх Засгийн газар удирдаж буй бөгөөд тэд гурван жилийн өмнө цэргийн эргэлт хийж, бүх эрх мэдлийг гартаа авсан юм.

Гэхдээ бүх нийтийн сонгууль явуулахаар товлож байгаа ч, цэргийн Засгийн газраас ардчилсан, иргэний оролцоот засаглал руу шилжих үйл явц удаашралтай байх хандлага ажиглагдаж байгааг олон улс судлаачид онцолжээ. Тайландад

Ерөнхий сайд асан Ийинглак Чинавыг огцрохыг шаардсан эсэргүүцлийн жагсаал газар авч, Засгийн газар, яам, тамгын газруудын үйл ажиллагаа бүрэн зогсох хэмжээний онц байдал үүсч байв. Улмаар Ерөнхий сайдыг дэмжигч болон эсэргүүцэгч гэсэн хоёр хэсэгт хуваагдсан иргэд хоорондоо мөргөлдөөн үүсгэж, эмх замбараагүй нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор хэв журам, тогтвортой байдлыг сахиулах зорилгоор цэргийнхэн бүх эрх мэдлийг гартаа авч, түр Засгийн газар байгуулан Ерөнхий сайдаар нь Прают Чан Оча томилогдсон билээ. Тэгвэл цэргийн Засгийн газрын

тэргүүн ойн өдрийн босгон дээр өнгөрсөн хугацаанд гарсан ололт амжилтыг онцолжээ. Тэрбээр “Өнгөрсөн гурван жилд гарсан хамгийн том үр дүн нь энх тайван, хэв журмыг эргүүлэн сахиулсан явдал” гэсэн байна. Улмаар үүний жишээ болгож, өнгөрсөн оны аравдугаар сард тусуульсын өмнөх эзэн хаан Пхумипон Адульдит таалал төгсч, хаан сэнтийг хоёр сарын дараа түүний хүү болох Маха Важирапонкорнд залгамжлуулахад, ямар нэг үймээн самуун гараагүй гэдгийг тодотгожээ. Гэтэл цэргийн эргэлт хийснээс хойш яг гурван жилийн ойн босгонд нийслэл Бангкок

хотын цэргийн эмнэлэгт тэсрэх бөмбөг дэлбэрч, 20 гаруй хүн шархадсан гэсэн мэдээлэл гарсан юм.

Нөгөөтэйгүүр, цэргийн Засгийн газар дэвшүүлсэн “Үндэсний шинэчлэл” болон “Үндэсний эвлэрэл” гэсэн бодлогынхоо хүрээнд тодорхой үр дүнд хүрч чадаагүй аж. Тус улсад таваас дээш хүнтэй улс төрийн цуглаан хийхийг хориглосон. Мөн өнөөгийн Засгийн газрыг шүүмжлэгч улстөрчид, нийгмийн зүтгэлтнүүдийг шахаж, хавчих явдал байсаар байгаа нь ард түмний эрх чөлөөг ноцтойгоор зөрчиж байсан гэх шүүмжлэл гарч эхэлмэгц интернэт дэх

хяналтыг чангатгаж, онлайн орчинд үйдэгдэх гэмт хэргийн тухай хуулийг шинэчлэн баталснаас гадна хэвлэл мэдээллийн тухай хуульд ч тодорхой заалтыг оруулан, эрх баригчид хяналтаа улам чангатгасаар байгаа юм.

Ийм үед дараагийн бүх нийтийн сонгууль 2019 он хүртэл хойшлогдож болзошгүй. Хэдийгээр цэргийнхэн 2018 оны сүүлийн хагаст явуулна хэмээн товлож буй ч, судлаачид “2019 оны сүүл үед сонгуулийг товлох магадлал өндөр байна. Засгийн газар сонгууль явуулах хугацаа нь болоогүй гэж үзвэл хугацааг сунгана” гэдгийг онцолж байгаа юм.

Пхеньян пуужингийн туршилт амжилттай болсныг зарлалаа

АНУ-ын эрх баригчид өнгөрөгч ням гарагт хэвлэлийн хурал зарлаж, “Бид Хойд Солонгос MRBM загварын дунд зайн тусгалт пуужин харвасныг тогтоосон. Энэ нь Пхеньяны өнгөрөгч хоёрдугаар сард туршсан баллистик пуужинтай яг ижил загварынх бөгөөд сүүлийн үед харвасан гурван баллистик пуужингаас арай богино зайд туссан” хэмээн мэдээлсэн юм. Үүнээс өмнө ч, БНСУ-ын хамгарсан цэргийн штабаас мэдэгдэл хийж, “БНАСАУ бямба гарагийн орой Өмнөд Пёнган нутгаас үл мэдэгдэх нисдэг объект хөөргөж, тэр нь ойролцоогоор 500 км зайд туссан” тухай мэдэгдсэн байдаг. Тэгвэл өчигдөр өглөө Хойд Солонгосын гал “Алтан гадас-2” гэх дунд зайн тусгалттай баллистик пуужинг амжилттай хөөргөн туршсанаа мэдээллээ. Тус пуужинг Хойд Солонгосын залуу удирдагч Ким Жон Уны тушаалаар харважээ.

Энэхүү пуужин нь шумбагч хөлөг онгоцноос хөөргөн туршидаг баллистик пуужингийн шинэчилсэн хувилбар аж. Тус улс 2017 оны хоёрдугаар сард энэ төрлийн пуужинг анх удаагаа хөөргөн туршсан юм. Умард Солонгосын мэдэгдэлд “энэхүү эвсгнийг цэргийн ажиллагаа явуулахад ашиглахад бэлэн болсон” гэжээ. Пуужинг амжилттай хөөргөн туршсаныг Ким Жон Ун сайшаахын сацуу түүнийг байрлуулахыг зөвшөөрсөн байна. Тэрбээр “пуужингийн туршилт 100 хувь төгс боллоо” гэжээ. Пхеньян баруун нутгийн Өмнөд Пёнган аймгийн Пүкчан хошуунаас холгүй орших газраас “Алтан гадас-2” пуужинг хөөргөсөн байна. Үүнээс нэг долоо хоногийн өмнө Умард Солонгос том цөмийн цэнэгт хошуу тээх боломжтой баллистик пуужинг харвасан билээ.

Пак Гын Хег өнөөдөр шүүнэ

БНСУ-ын Самсунг, Лотте зэрэг томоохон группээс авлига авсан гэх хэрэгт холбогдсон тус улсын анхны эмэгтэй Ерөнхийлөгч асан Пак Гын Хегийн анхны шүүх хурал өнөөдөр орон нутгийн цагаар 10:00 цагт Сөүлийн төв шүүхэд эхэлнэ. Тэрбээр, өнгөрсөн гуравдугаар сарын 31-нд баривчлагдаж, түүнээс хойш Сөүлийн зах хэсэгт байрлах цагдан хорих төвд хоригдож байгаа юм. Хэд хэдэн хэрэгт буруутгагдаж буй түүнд холбогдох хэргийг хэлэлцэх анхны шүүх хурал нь энэ. Шүүх хурлын үеэр тэрбээр прокуроруудын түүнд тулгаж буй ялыг хүлээн зөвшөөрөх, эсвэл урьдын адил гүйцгэх эсэх нь олны анхаарлыг татаж байна. Прокуроруудын хэвлэлийнхэнд мэдээлснээр сэжигтэн Пак найз Чой Сун Шилтэй хуйвалдаж, Самсунг корпорацийн удирдлагаас эрх мэдлээ ашиглан 29.8 тэрбум воны хахууль авсан аж. Мөн Лотте корпорацийн захирлаас сүлжээ дэлгүүрийг нь татвараас чөлөөнө гэх амлалт өгч, 70 тэрбум воны хахууль авсан гэх хэрэгт буруутгагдаж байгаа. Өнгөрөгч дөрөвдүгээр сард энэ мэт авлига, хээл хахууль, албан тушаалаа урвуулан ашигласан зэрэг нийт 18 хэрэгт буруутган түүнд яллах дүгнэлт үйлдсэн байдаг.



Тайваньд цэргийн сургуулилт эхэллээ

Тайваньд жил бүр болдог “Хань гуан” гэдэг нэртэй томоохон хэмжээний цэргийн хээрийн сургуулилтад зэвсэгт хүчний бүх төрлийн анги нэгтгэлүүд оролцохоор болжээ. Тайваны мэдээллийн төв агентлагийн мэдээлснээр, таван өдрийн энэ сургуулилт нь эх газрын Хятадтай болзошгүй мөргөлдөөн дэгдсэн тохиолдолд агаарын болон тэнгисийн довтолгооныг няцаах, байлдааны бэлэн байдлыг шалгах зорилготой ажээ. Уг хээрийн сургуулилын явцад болзошгүй дайны десантыг устгах, нисэх онгоцны буудал, тэнгисийн цэргийн бааз болон бусад стратегийн чухал объектыг хамгаалах ажиллагааг боловсруулан төлөвлөх, байлдааны буудлага хийх юм байна. Сургуулилтад цохилтын нисдэг тэрэг, сөнөөгч нисэх онгоц, хөлөг онгоц, хуягт техник, их буу болон тэнгисийн десантын амьд хүч болон техникийг устгах зориулалттай зэрэг галлах “Лэй Тин-2000” тийрэлтэт системийг ашиглах юм. Пүрэв гарагт сургуулилт



стратегийн хувьд чухал байрлал бүхий Тайваны хоолойд орших Пэнху арал дээр явагдана. Хээрийн сургуулилын явцыг нэг жилийн өмнөөс Тайваны Засаг захиргааг тэргүүлж буй Цай Инвэнь ажиглах ажээ. Хятадын Ардын чөлөөлөх арми

Цинцоаньганы нисэх хүчний баазд бөөн хүчээр агаарын цохилт өгсөн тохиолдолд явуулах хариу ажиллагааг баасан гарагт сургуулилах юм. Тайванийн гуравдахь том хот болох Тайжуны ойролцоо орших тус бааз нь хамгийн чухал цэргийн объект ажээ. Харин эргийн хамгаалалтын албаныхан Тайпин арлыг хамгаалах сургуулилт хийнэ. Энэ арал нь Тайваниас алс холд Өмнөд Хятадын тэнгист оршдог бөгөөд маргаантай байгаа Спратли бүлэг арлуудын нэг юм.

Өвөр Монголчууд монгол хэлний сан байгуулжээ

ӨМӨЗО-ны мэргэжилтнүүд хэл, соёлоо хамгаалах ажлын хүрээнд 19 сая үг хэллэг бүхий монгол хэлний мэдээллийн сан байгуулжээ. Уг мэдээллийн санг байгуулах амалыг Өвөр Монголын их сургуулиас 2012 онд анх санаачилсан бөгөөд мэдээллийн санг байгуулахын

тулд тус сургуулийн эрдэмтэн, багш нар 1980-аад оны монгол хэлний баримтуудыг цуглуулсан аж. Энэхүү мэдээллийн сангийн агуулга нь толь бичиг, дүрэм болон уран зохиол зэрэг өргөн цар хүрээг хамарчээ. Уг хөтөлбөрийг хариуцсан инженер Ян Сяофэн хэлэхдээ “Мэдээллийн сан бий

болгоход туслах үүднээс Өвөр Монголын их сургуулийн эрдэмтэн багш нар 1980-аад оны монгол хэлний баримтуудыг цуглуулж эхэлсэн” гэв. Мөн мэдээллийн санд монгол-мандалын хэлний цахим толь бичиг ажиллаж байгаа аж.

“Apple-1” компьютер 110 мянган еврогийн үнэ хүрвэ

АНУ-ын “Apple” корпорацийн ойролцоогоор 40 жилийн өмнө бүтээсэн “Apple-1” компьютер өнгөрөгч амралтын өдрүүдэд Германд дуудлага худалдаанд оролцож, 110 мянган еврогийн үнэ хүрчээ. “Apple-1” компьютер эдүгээ дэлхийд ердөө найман ширхэг л байдаг аж. Тэдний нэг болох дуудлага худалдаагаар үнэ хаялцуулан худалдаалсан уг компьютерыг зохион байгуулагчид нь 180-300 мянган еврогийн үнэ хүрнэ хэмээн таамаглаж байжээ. Гэсэн ч, уг үнэнээс хэд дахин бага буюу 110 мянган еврогийн үнэ хүрсэн байна. 2011 онд Apple” корпорацийн үүсгэн байгуулагч Стив Жобсыг нас барснаас хойш анх удаагаа тус нэрийн бүтээгдэхүүн ийм хэмжээний үнэ хүрч буй юм. Өмнө нь 2013 онд өөр нэг “Apple-1” компьютер 516 мянган еврогийн үнээр худалдаалагдаж байжээ. Стив Жобс, Стив Возниак нарын хамтран бүтээсэн тус компьютер ойролцоогоор 200 ширхэг үйлдвэрлэгдэжээ.



ОНЦЛОХ ХУУДАС

ТӨРИЙН АЛБАНЫ ХУУЛЬ УЛС ТӨРИЙН ЗОРИЛГОТОЙ ЮУ

Эсрэг тэсрэг байр суурь

Д.Эрдэнэбат: Маш их улстөржсөн хууль болсон гэж харж байгаа



/УИХ-ын гишүүн, УИХ дахь АН-ын бүлгийн дарга/

Эрх баригчдын оруулж ирж байгаа Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга улстөржсөн хууль болсон. Учир нь уг хуулийн ихэнх заалтууд улс төрийн байгууллагуудад буюу Засгийн газарт бүх эрх мэдлийг өгсөн байгаа. Улмаар Төрийн албаны зөвлөлийг үгүйсгэсэн буюу дагавар байгууллага болгох гэсэн оролдлого байсан. Хуулийн 10 гаруй заалтад ЗГХЭГ-т бүх асуудлыг төвлөрүүлэхээр заасан нь өөрөө улстөржүүлсэн хууль гэдгийг баталсан хэрэг. Харин Ерөнхийлөгчийн санаачилсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь одоогийн үйлчилж байгаа хуульд дутуу байсан зүйлүүдийг нэмэлтээр товч тодорхой оруулж ирсэн гэж харж байгаа. Гэхдээ бид ажлын хэсэгтэй хамтраад, хэлэлцүүлгийн үр дүнд гарсан 10 гаруй саналуудыг ажил хэрэг болгох хүрээнд хамтарч ажиллахад бэлэн байгаа. Одоо мөрдөгдөж байгаа Төрийн албаны хууль сайн хууль. Гэхдээ хэрэгжихгүй байгаа зүйл заалтуудыг хэрэгжүүлэхэд садаа болоод байгаа зүйлүүдийг засч залруулах тухай асуудал байсан. Гэтэл эрх баригчдын оруулж ирсэн шинэ хуулийн төсөл нь өөрөө одоогийн хуулиас зүйл, заалтын хувьд гурав дахин нүсэр хууль орж ирсэн. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчдын хаашаа харах, хаана суух вэ гэдгээс эхлүүлэн захирагчаны шинжтэй журмаар зохицуулагдах бүх зүйлийг энэ хууль руу хичсэн нь буруу. 2016 оны сонгуулийн дараа нийтдээ 22235 төрийн албан хаагч ажлаасаа халагдсан байна. Тиймээс эрх баригчид Төрийн албаны тухай хуулийг яаран батлах гэж байгаа цаад учир нь улс төрийн аргаар дээрхи солигдсон төрийн албан хаагчдыг төрийн албан хуулиар хадгалах үлдээх оролдлого хийж байж ч болзошгүй гэсэн хардлага төрүүлж байгаа.



Я.Санжмятав: Хуулийг хэтэрхий яарч өөрчлөх хэрэггүй

/УИХ-ын гишүүн, УИХ-ын дэд дарга/

Шулуухан хэлэхэд энэ хуулийн шинэчлэлд сэтгэл дундуур байгаа. УИХ-ын нэр бүхий гишүүдийн санаачилсан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь долоон хэсэг, 33 бүлэг, 109 зүйлтэй байна. Энэ нь өмнөх хуулиас бүлэг, зүйлийн тоо нь 3-5 дахин нэмэгдэж маш том хууль болжээ. Зүйл заалтын тоо ихэсч хуудасны тоо олон болсноор хууль сайн болохгүй. Энэ бол амьдралаар батлагдсан үнэн. Миний байр суурь бол өмнөх хуулийнхаа суурин дээр сайжруулах, зохицуулах, өөрчлөх шаардлагатай зүйл хэсгээ тусгаад явах ёстой гэж бодож байгаа. Хуулийн шинэ төсөлд тусгаснаар бол улс төрийн намын гишүүн төрийн албанд ажиллахаар бол намын гишүүнээсээ татгалзах заалт байна. Уг санаа нь зөв л дөө. Гэвч Үндсэн хуульд зарим төрлийн албан хаагчийг намын гишүүнээс түдгэлзүүлж болно гэж байгаа. Тэрнээс татгалзана гэсэн заалт байхгүй. Мөн Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг заавал биедүүлэн, Шүүхэд гомдол гаргаж болохгүй гэсэн агуулга байна. Энэ нь Үндсэн хууль дахь хүний эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн тохиолдолд Шүүхэд гомдол гаргах эрхийг хөндсөн ноцтой асуудал болох нь. Ийм илэрхий бүдүүлэг, бярдсан агуулга, үзэл санааг хавчуулж болохгүй л дээ. Энэ нь ямар зорилготой юм гээд цааш ярина. Тэгээд ч Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудлыг хөндөн ярьж байгаа өнөөдрийн цаг үед төрийн албаны тухай хуулийн шинэчлэлээ эцэг хуультайгаа сайтар уялдуулсан зохицуулалт оруулах нь чухал гэж харж байгаа. Өнөөдөр эрх барьж байгаа нам нь өөрсдийнхөө эрх ашигт илүү нийцүүлсэн нэг хууль гаргана. Маргааш нөгөө нам нь та нар өөрсдөдөө тохируулж хийсэн гээд дахин өөрчилнө. Ийм байхаар Төрийн албаны тогтвортой байдал, улс төрөөс хараат бус байх зарчим алдагдсаар л байна. Тэгэхээр энэ хуулийг олуулаа олон талаас нь ярьж, олон жилийн настай хууль баталмаар байна. Хуулийг хэтэрхий яарч өөрчлөн батлах гээд хэрэггүй. Бушуу туулай борвиндоо баастай гэдэг шинэ хэтэрхий гоомой хууль гарчих вий гэдэг болгоомжлол үндсэндээ аль аль талдаа байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Эх сурвалж: Өдрийн сонин

Сэтгүүлчийн дүгнэлт

ОРОНДОО ХУУЛЬ ЗАСАХ ЮУ Ч БИШ БАЙЖЭЭ

Б.ӨНӨРТӨГТӨХ

Найзууд ярьж суугаад шинэ бүтээлийн санаа олох, гэсвэл шар айраг ууж суухдаа хамтлаг байгуулах “гэнэн” санаа төрдөг шиг манай улстөрчид хов базаж суухдаа хууль өөрчлөх мэргэн санаа олдож болоод удаж байна. Ц.Нямдорж гишүүн орондоо хууль засч байсан нь үүний дэргэд юу ч биш байжээ. Улс төрийн нам болгон хууль өөрчлөх ёстой юу гэвэл тийм биш. Тэр тусмаа зүв зүгээр хэрэгжиж байсан хуулийг эрс өөрчилж, өмнөхөөс нь дордуулж байгаа нь хэрхэвч зүгээр харж суух асуудал биш юм. Өвөрхангай аймгаар олон жил овоглосон Д.Тогтохсүрэн 2016 оны сонгуулиар ёстой л “тэнгэрийн умдаг атгасан”. УИХ-ын гишүүний зөвлөн сэнтийд заларч, олон жилийн хүслээ биелүүлж байгаа азтай нэгэн. Гэтэл УИХ-д орж ирээд нэг жил ч болоогүй байхдаа Үндсэн хуулийн араас орох том хууль болох Төрийн албаны хуулиар оролдож сууна. Туршлагагүй атлаа тэр том сэдвийг оролдож, боловсруулсан хуулиа ч хамгаалж чадахгүй онигоо болж байгаа нь худлаа биш. Төрд орж ирээд нэг жил болсон нь байтугай, гурав дөрвөн удаа улирч сонгогдсон гишүүд ч барагтай бол барьж авахгүй хуулийн төслөөр оролдож эхэлжээ. Үгүй мөн том зориг шүү.

Эрхэм гишүүн өөрийн намын хэсэг гишүүдтэй ярилцаж суугаад хууль өөрчлөхөөр шийдсэн гэнэ лээ. Намын дарга нь ч УИХ-ын чуулганы индэрээс Төрийн албаны тухай хуулийг өөрчлөх нь МАН-ын мөрийн хөтөлбөрийн нэг том зорилт хэмээн мэдэгдсэн удаатай. Гэхдээ хууль өөрчлөх нийгмийн шаардлагаар тоглолт хийж юу хүссэнээ шүргүүлж, өөрчилж болох уу. Тэр тусмаа хэдэн зуун мянган хүний амьдралтай холбоотой ийм том хуулийн төслийг ямар ч хэлэлцүүлэг, судалгаа, экспертүүдийн санал авахгүйгээр хэдхэн гишүүн ярилцаад оруулж ирдэг нь арай л хэрээс хэтэрсэн үйлдэл байлтай. Төрийн албаны тогтворгүй байдал, улстөржилт, хоморголон халж буй асуудлыг өөрчлөх нийгмийн шаардлагаар халхавч хийж түүнийг өөрчлөх бус харин ч эсрэгээрээ улс төрийн ашиг сонирхлоо баттай суулгахаар санаархжээ хэмээн хардах үндэслэл хэд хэд байгаа юм. Тухайлбал, эрхэм гишүүний хэлсэнчлэн Төрийн албаны зөвлөл сонгон шалгаруулалт явуулдаг, шалгалт авдаг, төрийн албан хаагчдын нөөц бүрдүүлдэг үндсэн үүргээсээ татгалзаж “шүүх” байгууллага болох гэнэ. Нөөц бүрдүүлэх, албан хаагчдыг томилгоо асуудлыг нь ЗГХЭГ эрхэлж, харин энэ томилгоо нь хууль зөрчсөн үү, хууль ёсны томилгоо хийгдсэн үү гэдгийг Төрийн албаны зөвлөл шалгаж тогтоох юм байх. Нэг ёсноо хоёр хүний хэрүүлгийг зохицуулдаг хөндлөнгийн байгууллага болно хэмээн хуульд тусгажээ. Энэ ажлыг төрийн албаны зөвлөл бус шүүх шийдэх учиртай. Гэтэл шүүх байгууллагын ажлыг булааж авахаар санаархсан нь энэ хуулийн үнэн төрхийг илчлэх биз ээ. Шууд утгаараа улс төрийн нөлөөлөл улам бүр гүнзгийрэх нь тодорхой байна.

ЗГХЭГ-ын дарга улс төрийн албан тушаалтан байдаг. Тийм хүнд монгол төрийн албан хаагчийн бүх асуудлыг даатгаж байгаа нь улс төрийн намууд юу хүссэнээ хийх боломжийг бүрдүүлж байгаа хэрэг хэмээн хардахаас өөр арга алга. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Төрийн албаны тухай хуульд төрийн албаны шалгалтад хамгийн өндөр оноо авсан хүн уг албан тушаалд тэнцдэг байх шалгуур бий. Гэтэл шинэ хуульд төрийн албаны шалгалтад хамгийн өндөр оноо авсан тав хүртэлх төрийн албан хаагчаас нэгийг нь сонгож, томилно гэж тусгасан байна. Тэгэхээр тухай албан тушаалд таван хүн өрсөлдөхөд онооны жагсаалтаар хамгийн сүүлд нь буюу тавдугаарт орсон хүнийг ч томилж боломжтой болох нь. Энэ мэтээр маш олон буруу зөрүү зүйл заалт шинэ хуульд туссан нь улстөрчдийн талцах, маргалдах шалтгаан болоод байгаа. Мэдээж МАН эрх мэдэлтэй. Тэд 65-уулаа улс төрд сууж байна. Тиймээс хэн нэгний эсэргүүцэл, сөрөг хүчний шаардлагыг үл тоон энэ хуулийг батлах нь дамжиггүй. Баталсан хуулиараа далайлган юу хүссэнээ хийх нь ч тодорхой. УИХ-ын гишүүнээр нэг жил ч ажиллаагүй, аймгийн Засаг даргын туршлагатай нэг улстөрчөөрөө туг тахиад ч хамаагүй хуулийг өөрчлөх нь тодорхой байна. Харин үр дүн яаж гарахыг тэд мэднэ гэж найдъя. Хуулийг хүслээрээ өөрчилж, буруу зөвийг ч ялгахгүй хууль баталж давхсаар гудамжинд гарсан АН-ын хувь заяаг МАН давтах нь тодорхой биз ээ. Ард түмэн тэнэг биш. Хов базаж суухдаа хүслээрээ хууль өөрчлөх цаг хугацаа ч хязгаартайг Д.Тогтохсүрэн таньд сануулах нь илүү биз. Монгол төрийн алтан хайрцаг болсон төрийн албаар оролдох аугаа том эр зориг таньд байгааг үнэлэхээс өөр яалтай. Тийм том хуулийг намынхаа өмнөөс бамбай болон барьж авсан таныг эр зоригийг л үнэлбэ дээ. Өөрчлөлт шинэчлэлт хүлээх нь илүүц гэдэг нь тодорхой.



Д.Тогтохсүрэн: Би эр зориг гаргасан

/УИХ-ын гишүүн/

Төрийн албан тодорхой хэмжээнд сайжирч байгаа ч сүүлийн жилүүдэд халаа сэлгээ нэмэгдсэн. Энэ хэрээр төрийн алба тогтворгүйжиж, чадавч нь муудсан. Үүнд олон нийт шүүмжлэлтэй ханддаг. Тиймээс төрийн албыг иж бүрнээр нь шинэчилж гэсэн санаачилгыг 12 гишүүн гаргаж, шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Ингэхдээ төрийн албыг улс төрөөс хараат бус, тогтвортой, хариуцлагатай байлгах, түүнчлэн Төрийн албаны зөвлөл ямар чиглэлтэй үйл ажиллагаа явуулах вэ гэсэн дөрвөн том асуудлаар өөрчлөлт оруулсан. Төрийн албан хаагчийг улс төрөөс хараат байлгах хэд хэдэн заалт орсон. Тухайлбал, бүтцийн өөрчлөлт нэрээр төрийн албан хаагчдыг хоморголон халж яам агентлаг, аймаг сумын албадын нэрийг өөрчилдөг. Үүнийг зогсоож бүтцийн өөрчлөлтөөр төрийн албан хаагчийг халахгүй болгоно. Хоёрдугаарт, ажлын байрны тодорхойлолтоо өөрчилж хүн халдаг байсныг өөрчилж, зургаан жилд нэг удаа ажлын байрны тодорхойлолт гаргадаг байхаар өөрчилсөн. Гуравдугаарт, төрийн албанд сонгууль болгоны дараа шинээр хүн орж ирдгийг өөрчилнө. Тухайлбал, яамны төрийн нарийн бичгийн дарга хүн төрийн албанд 16 жил ажилласан байх ёстой гэж тусгасан. Төрийн албаны зөвлөл төрийн албан хаагчийг сонгон шалгаруулдаг газар. Тэгвэл энэ чиг үүргийг өөрчилж Төрийн албаны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьдаг газар болгоно. Тухайлбал, сонгон шалгаруулалт зөв хийгдсэн эсэхэд хяналт тавьж, маргааныг эцэслэн шийдвэрлэнэ. Товчхондоо Төрийн албаны зөвлөл маргаан таслах, шийдвэрлэх, буруу томилсон, чөлөөлсөн байвал тухайн шийдвэрийг хүчингүй болгоно. Удирдах албан тушаалтны буруугаас болж төрийн албан хаагч хууль бусаар халагдсан нь тогтоогдвол хохирлыг тухайн дарга өөрөө төлж барагдуулна. Өнгөрсөн сонгуулиар МАН төрийн албан хаагчдыг тодорхой хэмжээгээр халж сольсон ч хоморголон халсан асуудал байхгүй. 2008-2012 онуудад халаа сэлгээ харьцангуй гайгүй явж ирсэн. Сүүлийн жилүүдэд л 15-20 мянгад хүрчихээд байна. Энэ өөрчлөлтийг хэзээ нэгэн цагт аль нэг улс төрийн хүчин хийнэ. Энэ бол яах аргагүй зориг. Аль нэг нам өөрчлөх гэхээс илүүтэй монгол төрийн алтан аргамжаа болсон “хар хайрцаг”-ны бодлогыг тогтвортой авч явдаг залгамж чанарыг барьж байдаг төрийн албан хаагчид маань тогтвортой, бас хариуцлагатай ажиллах ёстой.

Эх сурвалж: Монголын үнэн

ОРОН НУТАГ

ХҮНД ҮЕД ГАДААД ГҮЙЦЭТГЭДЭГ

хэсэг хугацаанд зогсонги болж ирснийг 2016 оноос сэргээлээ. Хоёр тал харилцан янз бүрийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, манайхан Кёнги аймаг болон Квонжу хотоос тусламж, дэмжлэг авдаг, харилцан айлчлал хийдэг байсан юм билээ. Хамтын ажиллагааг сэргээхэд Солонгосын ЭСЯ онцгой үүрэг гүйцэтгэсэн. Дараа нь бид өөрсдөө харилцан ярилцаж, санал бодлоо солилцсон.

АНУ бус Элчин сайдын яамтай нь хамтарч ажилладаг юм байна гэж ойлгосон. Эсвэл би буруу ойлгосон уу?

АНУ-ын Элчин сайдын яамтай Дорноговь аймаг маш дотно харилцаа ирсэн. АНУ-ын буцалтгүй тусламжаар Замын-Үүд суманд 50 хүүхдийн цэцэрлэг баригдахаар болсон. Хамгийн гол нь дэлхийн стандартад нийцсэн цэцэрлэг байх юм. Хамгийн сүүлийн үеийн дэвшилтэд техник технологи ололт амжилтыг ашиглахаас гадна гамшгийн үед тавигдах шаардлагыг хангана. Цэцэрлэг маань наймдугаар сард баригдаж эхлэнэ. Шав тавих ёслолын арга хэмжээ өнгөрсөн дөрөвдүгээр сард болсон. Монгол Улсын Боловсролын яам ч дэмжиж, Дорноговь аймагт цэцэрлэг байгуулах нөхцөл боломжийг олгосон. АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Женефер Галттай манай засаг дарга Т.Энхтүвшин өмнө нь уулзаж, цаашид хэрхэн хамтран ажиллах талаараа санал солилцож байсан нь ийнхүү ажил хэрэг болж, үр дүн нь одоо гарч байна гэж дүгнэж байгаа. Түүнчлэн төрийн үйлчилгээний "Соёмбо" цогцолборт номын сан байгуулж, хамтын ажиллагааны гэрээтэй улс орнуудын соёл, мэдээллийн төв байгуулахаар шийдвэрлэсэн. Энэ хүрээнд АНУ-ын Соёл, мэдээллийн төв болон англи номын сан ажиллуулахаар хоёр тал тохиролцсон. Төвөөр дамжуулаад англи хэлний сургалт явуулахаас гадна

иргэдэд мэдээлэл өгнө. АНУ, Монгол Улсын хооронд дипломат харилцаа үүссэний 30 жилийн ойн хүрээнд Монгол Улсын Гадаад харилцааны яам, АНУ-ын Элчин сайдын яам, Дорноговь аймгийн ЗДТГ хамтран зохион байгуулах жилийн ажлыг төлөвлөгөө саяхан батлагдсан. Өнгөрсөн дөрөвдүгээр сарын 2-3-нд Дорноговь аймгийн англи хэлний багш нарын заах арга зүйг сайжруулах сургалтыг Элчин сайдын яам, "Энхтайван"-ны корпусын сайн дурын мэргэжилтнүүд, МУИС-ийн багш нартай хамтран зохион байгууллаа.

Турк улсын Дуже мужтай байгуулсан гэрээний талаар тодруулбал?

Туркийн Дуже мужтай 2015 оны дөрөвдүгээр сарын 15-нд Түрэг хэл, соёл угсаатны холбоогоор дамжуулан эгч дүү хотын харилцаа тогтоосон байсан авч улс төрийн янз бүрийн шалтгааны улмаас тасарсан юм билээ. Үүнийг 2016 онд сэргээсэн. Туркээс хотуудын Засаг дарга нар Дорноговь аймагт айлчлах үед үйлдвэр, үйлчилгээ, аялал жуулчлалын чиглэлээр хамтран ажиллахаас гадна мах, арьс шир боловсруулах үйлдвэр барихаар харилцан ярилцсан байдаг. Тэр бүхнийг сэргээхийн төлөө бид ажиллаж байна. Ойрын үед Түрэг угсаатны холбоотой хамтран жил бүр Турк улсад зохион байгуулагддаг хүүхдийн урлагийн их наадамд оролцох төлөвлөгөө бий. Дашрамд өгүүлэхэд, манай аймаг Солонгосын Зүүн хойд Азийн засаг захиргааны холбоотой маш амжилттайгаар хамтран ажиллаж буй. Энэ байгууллагад БНХАУ, БНСУ, ОХУ, Монгол, Японы 80 гаруй муж, хотуудын засаг захиргаа, манай 21 аймаг гишүүнээр элссэн байдаг юм. Гишүүн байгууллагууддаа зориулж нэлээд олон ажлыг зохион байгуулдаг. Гадаад харилцааны мэргэжилтнүүдийн сургалт, залуу удирдагч форум гээд олон арга хэмжээг зохион байгуулдаг. Ирэх наймдугаар сард Бусон хотноо залуучуудын дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулахаар болсон. Манай аймгийн шилдэг, тэргүүний залуучууд энэхүү арга хэмжээнд оролцохоор мэдүүлгээ өгөөд байгаа.



Аймагас мэдээлж байна

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

“Хүүхэд гэр бүлдээ аз жаргалтай” өдөрлөг боллоо

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1993 оны есдүгээр сарын 20-ны хэлэлцээрээр 1994 оноос эхлэн жил бүрийн тавдугаар сарын 15-ны өдрийг “Гэр бүлийн өдөр” болгон тэмдэглэж байх тогтоолыг баталсан байдаг. Улс үндэстэн энх тайван оршин тогтнох хамгийн бага нэгжүүдийн нэг бол гэр бүл гэж үздэг. Тэгвэл дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан Говьсүмбэр аймгийн ЗДТГ, ГБХЗХГ, дуу бүжгийн “Боржигин” чуулга, Дэлхийн зөн Бор-Өндөр ОНХХ-тэй хамтран “Хүүхэд гэр бүлдээ аз жаргалтай” өдөрлөгийг зохион байгууллаа.

Өдөрлөгт ОУУБИС-ийн Ph.D Б.Оюун-Эрдэнэ “Хүүхэдгэрбүлдээазжаргалтай”сэдвээрлекцтавилаа. Мөн шилдэг есөн гэр бүлийг шалгаруулж “Спортлог гэр бүл”-ээр Н.Идэржавхлан, Д.Солонготуяа, “Авьяаслаг гэр бүл”-ээр Д.Нацагдорж, С.Дулмаахүү, “Хүмүүнлэг гэр бүл”-ээр Я.Дамдиндоо, Ч.Болормаа, “Оюунлаг гэр бүл”-ээр Д.Амарсайхан, Д.Зандарьяа, “Хөдөлмөрч гэр бүл”-ээр Д.Жамсран, Ө.Дэлгэр, “Өв соёлоо дээдлэгч гэр бүл”-ээр Г.Ганхуяг, “Үлгэр жиншээч гэр бүл”-ээр Д.Цогбадрах, М.Сэртэв, “Өнөр гэр бүл”-ээр Д.Жаалхүү, “Бүтээлч гэр бүл”-ээр Ц.Бөхбат, Р.Баасансүрэн нарын гэр бүлүүдийг шалгаруулж өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулсан байна.

Сонгуулийн хэсгийн хороодыг сургалтад хамруулжээ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зургадугаар сарын 26-нд орон даяар явагдана. Сонгууль зохион байгуулах бэлтгэл ажилтай холбогдуулж, Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдсан хуваарийн дагуу аймаг, сумдын хэсгийн хороонд сонгуулийн санал тоолох төхөөрөмжийг хариуцан ажиллах мэдээлэл технологийн даамлын сургалтыг зохион байгуулж эхлээд байгаа билээ.


Тус сургалт Говьсүмбэр аймагт энэ сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан байна. Сургалтыг Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн программ хангамжийн инженер П.Алтанчимэг, С.Отгонсүрэн нар сонгуулийн автоматжуулсан систем, түүний эрх зүйн орчин, санал тоолох төхөөрөмж, зурган файл хуулах, өгөгдөл дамжуулах туршилтын өдрийн заавар, санал тоолох төхөөрөмж дээр ажиллах дадлага ажил, гарч болох зарим асуудлыг шийдвэрлэх талаар мэдээллийг өгч, төгсгөлд нь бичгээр шалгалт авч үнэмлэх, гэрчилгээг олгожээ.

ХЭНТИЙ АЙМАГ

“Музейн өдөр”-ийг тэмдэглэлээ

Жил бүрийн тавдугаар сарын 18-ныг “Олон улсын музейн өдөр” болгон дэлхий нийтээр тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Дээрх өдрийг 1978 оноос дэлхийн 150 гаруй оронд тэмдэглэх болсон бөгөөд манай орны хувьд 1992 оноос тодорхой уриан дор тэмдэглэсээр иржээ. Тус тэмдэглэлт өдрийн хүрээнд Хэнтий аймгийн музейгээс орон нутгийн иргэд, албан байгууллагуудад ажилтнуудад зориулсан “Музей үзэх өдөр” арга хэмжээ, музейн өдрийн албан ёсны нээлтний үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Хэнтий аймгийн Музейн хамт олноос тус өдрийг угтаж олон арга хэмжээг зохион байгуулжээ. Үүнд, Хэрлэн сумын ЕБ-ын Лаборатори Нэгдүгээр сургуулийн Ц.Сансармаа багштай 8в ангийн сурагчдад Чингис хотгой танилцах “Тайлбарт аялал”, “Хаадын хөрөг” үзэсгэлэн, Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад “Их Эзэн Чингис хааны өлгий нутгийн гайхамшиг” сэдэвт лекц, Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн Ахлах бүлгийн сурагчдын дунд “Бидний бүтээл” музейн боловсролын ажил, Аймгийн төрийн албан хаагчдын дунд Аймгийн Засаг даргын нэрэмжит “Түүхт Хан Хэнтий” эссэ бичлэгийн уралдаан зэргийг зохион байгуулж иргэдэд музейн үйл ажиллагааг сурталчлан таниуцуулжээ.



УЛАМЖЛААТ АНАГААХ УХААНЫ "ГАНЗҮҮ" ЭМНЭЛЭГ

Манай эмнэлэг дотор 5 цуа, 6 сав эрхтэний өвчлөлийг уламжлалт анагаах ухааны таван заслын аргаар эмчилж, 80-аас дээш хувьтай үр дүн үзүүлдэг.

- Бид танад:**
- Ган болон мөнгөн зүү, шалнагаан зүү
 - Хануур, сам соруул
 - Шарлага
 - Бумба төвшнө засал
 - Халуун чулуу, давсан халуун жинн засал
 - Эмчилгээний цэгэн бариа
 - Архи, сүү, сүүлэн тостой бүтэн биеийн бариа зэрэг уламжлалт анагаах ухааны эмчилгээ үйлчилгээ, мэдрэл, харшил, хүүхэд, эмэгтэйчүүдийн оношлогоо эмчилгээг цогцоор нь хийж үйлчилнэ.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ БИД ҮЗҮҮЛНЭ
Холбогдох утас: 9999-5584
9900-2332



Салбар 1 хаяг: Найрсаг Улаанбаатар их дэлгүүрийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Өдрийн эмчилгээ/



Салбар 2 хаяг: III хороолол, 28 дугаар сургуулийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Хэвтүүлэн эмчилнэ/



Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 27
Шөнө 8

Нөгөөдөр
Өдөр 31
Шөнө 12

Өдрийн зурхай

ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ЦАГААН НОХОЙ ӨДӨР

Наран ургах шингэх: 05.05-20.33
Үс засуулбал: Эд эдлэл идээ ундаа олдono



Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд зөрөө сайн ба бич, тахиа жилтнээ соргог луу нолоотэй тул элдэ үйлд хяналгай хандаж, бие энхрийлүүртэй. Буян үйл үйлдээс олзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, алирлуулах, дэлгэрүүлэх, эрхнээх үйл нигүүд бүтээх, хувцас хийх, гэр орон барих, сан нуун дарахад сайн. Зүүн нүүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүүд татвал эд олдох, зүүн чих хангинавал айлшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэлцэл болох, хэрэг дуугарвал зочид ирэх, тагнай загатнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хөл татвал үзэсгэлэн болно. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.

Брэд Питт: Одоо энэ бүхнийг өөрчлөмөөр байна

Б.СУМЬЯА

Холливудын нэрт жүжигчин Брэд Питт сүүлийн үед хэд хэдэн сэтгүүлд илэн далангүй ярилцлага өгсөн байдаг. Брэд Питт 2014 онд 10 жил хамтран амьдарсан Жюлитой хуримлаж, хосууд өөрийн гурав, өргөмөл зургаан хүүхэдтэй болсон билээ. Гэвч, Брэд хүүхдүүдтэйгээ тааламжгүй харилцсан гэх шалтгаанаар хосууд салахаар болсон нь өнгөрсөн оны дуулиант салахын нэг байлаа. Тэрхүү салалтаас хойш уран барималд шимтэж, басхүү шинэ уран бүтээлд тоглоод амжсан Брэд Питт хувийн амьдрал хийгээд уран бүтээлийн талаар "GQ" сэтгүүлд ярьжээ. Тус ярилцлагаас "Оддын цаг" буландаа орчуулан хүргэж байна.

Өнгөрсөн зургаан сарын хугацаанд юу мэдэрч, хэрхэн өнгөрүүлэв?

-Мэдээж, гэр бүлээ нэгдүүгээрт. Хүн гэдэг амьтан үхлийн ирмэгт тулж ирэхдээ яаж шагнуулж, юуг өөрийн болгосноо бус, хайрладаг хэн нэгнээ, эсвэл хамгийн их харамсдаг зүйлийнхээ талаар л ярьдаг. Тиймээс асуудлаа тэр дор нь шийддэг байх хэрэгтэй гэдгийг хүмүүст хэлмээр байна. Хүүхдүүд их эмзэг. Бүхий л зүйлийг таньж мэдэхийг хичээдэг. Тэд бүхий л зүйлсээс тайлбар шаардана. Бас тэднийг сонсох хэрэгтэй болно. Би завгүй ажилладаг учраас тэднийг тэр бүр сонсч чаддаггүй. Одоо энэ бүхнийг өөрчилмөөр байна.

Хэрвээ та гэр бүлээ дахин нэгтгэж чадвал, өмнөхөөсөө хавь илүү өөр нэгэн гэр бүлийг бүтээж чадна гэдэгтэй итгэлтэй байгаа байх?

-Би тэдний итгэж найдаж байгаа, эсвэл ирээдүйд тулгарч болох, яг одоо өмнө нь тулгарч буй бүхий л зүйлийг нь хийж өгөхийг хичээдэг. Гэр бүлд хэт их гэрэл эсвэл хар бараан зүйл багахан байхыг ч хүсдэггүй. Гэтэл амьдралын зам дандаа дардан байхгүй. Заримдаа хаа нэг тийш хазайх үе гарна. Энэ бол өөр ертөнц. Бид сэтгэлзүйд илүү их анхаарал хандуулдаг шүү дээ. Нэг сул тал нь бидний сэтгэл хөдлөл ижил байдаг юм байна. Би илүү сайн эцэг байх ёстой. Би өөрөө

эцэг гэдэг хүн бүгдийг чаддаг, хамгийн хүчтэй, супер хүн гэж ойлгодог орчинд өссөн. Энэ ч бидний салалтад цохилт үзүүлсэн байх. Одоо би илүү сайн байх болно. Тэдэнд сайн байгаагаа харуулах ёстой.

Асуудал хаашаа эргэх нь тодорхойгүй нөхцөлд бүр ч хэцүү байх нь мэдээж?

-Хэсэг хугацаанд надад тийм асуудал тулгарсан. "Хүүхдийн үйлчилгээ" гэх системд гинжлэгдэж, бүх зүйл нуруун дээр ирсэн. Харин дараа нь энэ бүх асуудлыг цэгцлэхийн тулд бид хамтдаа ажиллах хэрэгтэй болсон. Бид хамтдаа хамгийн сайнаараа асуудлыг шийдэхийг хичээж байна. Нэг хуульч ингэж хэлсэн юм. "Шүүх хуралдаанд ялагч гэж байдаггүй. Зөвхөн хэн хамгийн их шархалсан бэ гэдэг тухай л асуудал" гэж. Энэ үг үнэн юм шиг санагдсан. Нэг жилийн хугацааг хэний буруу, хэнийх нь зөв болохыг тогтооход зориулна гэдэг дэндүү хайран. Нөгөө л нэг нэгнээ үзэн ядахад хувь нэмрээ оруулж буй хэрэг. Би үүнээс татгалзсан. Аз болоход, Жюли ч үүнийг зөвшөөрсөн. Хүүхдүүдтэйгээ ойлголцохгүй бол, гэнэт л гэр бүлд ан цав үүсч эхэлдэг юм.

Яг л үүнийг би таниас асуух гэж байлаа?

-Бид хэн нэгний хувьд утга учиртай нэгэн байхыг хүсч байвал тэдэнд анхаарал тавьж, ойлгож, эргэн тойрны бүхий л зүйлсийг хамтдаа бүтээх хэрэгтэй юм

билээ.

Хүүхдүүддээ энэ талаар яаж хэлэх вэ?

-Тэдэнд маш олон зүйл хэлмээр байна. Бидний ярилцаагүй өнгөрсөн цаг хугацаанд тохиолдсон явиргатай олон асуудал, яагаад тийм зүйл болсон, тэдний ойлгох, эсвэл ирээдүйд ойлгох тэр бүхний тухай яриаар байна. Тэднийг илүү сайн, илүү хүчирхэг нэгэн болгохыг л зорьж буй учраас ямар нэг үр дагавар гарахгүй байх.

Ний нуугүй хэлэхэд, хүмүүс хэнд ч ойлгомжтой зүйлийн тухай ярихдаа огт болоогүй, тохиолдоогүй мэт ярих нь бий. Гэтэл шүүхээс салгах шийдвэр гарлаа гэж бодоход, хар дарсан зүүд мэт нөхцөл байдал үүсч болно шүү дээ?

-Дайсагнал. Хаа сайгүй л үүнийг харж болно. Нэг нэгэнтэйгээ дайсагналцаж, хэдэн арван жилийг үй гашуу, үзэн ядалт дунд өнгөрүүлж буй жишээ олон байгаа. Чи өөрөө шүүх хурлаар асуудлаа шийдүүлдэг үз. Тэр үед энэ бүх зүйл чухал биш болдог гэдгийг мэдрэх болно. Яах вэ, бага зэрэг айдас төрнө. Миний үзэх дуртай кино "There will be Blood". Би яагаад энэ кинонд дуртай байдгаа хэлж мэдэхгүй. Даниэл Дэй, Пол Т нарын тоглосон энэ гайхалтай кинонд зүгээр л дуртай байдаг юм. Гэхдээ би маргааш өглөө сэрээд, "өө новш, энэ кино бүхэлдээ тэр залуу болоод түүний үзэн ядалтын тухай харуулсан байна шүү дээ" хэмээн бодол өөрчлөгдөж болно. Амьдралд яг л үүн шиг ой гутмаар

мөч олон тохиолддог. Нэг найз маань салсан эхнэрээ амьдралынх нь нэг хэсэг байсныг хүлээн зөвшөөрөхийг хүсдэггүй. Тэгсэн атлаа нэг нэгэнтэйгээ өрсөлдөж, тэмцэлдэж олон жилийг зүгээр л дайсагнал дунд хий дэмий үрж байгааг харж л байна. Би тийм замаар явахыг хүсэхгүй байна.

Бусад хүмүүс таны талаар юу бичих бол гэдэгт санаа зовж байна уу?

-Энэ талаар би үнэхээр санаа зовохгүй байна. Намайг хайрладаг хүмүүс намайг мэддэг гэдгийг би мэднэ. Энэ л миний хувьд хангалттай. Хэн нэгнийг хайрлаж байгаа бол тэднийг чөлөөл. Энэ үг ямар утгатай болохыг одоо би мэддэг бас мэдэрдэг болсон. Энэ бол өөрийн эрхшээлд, өөрийн өмчлөлд байлгах гэж оролдохгүйгээр хайрлах гэсэн үг юм.

Сэтгүүлийн зураг авалтын хувьд гурван үндэсний соёл амралтын хүрээлэнд очсон байсан. Энэ талаар?

-Тийм ээ, үнэхээр гайхалтай байсан. Зурагчин Ryan "Everglades" хүрээлэнд энд тэнд гараад л гайхалтай зураг авалт хийсэн.

Мөн цагаан элс?

-Би урьд нь хэзээ ч тийм зүйлийг харж байгаагүй. Тэр элсэн манхан үнэхээр гайхалтай бас орчин үеийн, шинэлэг, зүгээр л төгс мэдрэмжийг надад төрүүлсэн.

Харин гурав дахь нь?

-Бид "Carlsbad Caverns"-д очсон. Хэрвээ бид гайхалтай зураг авахыг хүсч байвал хамтарч ажиллах нь чухал шүү дээ.

ШИНЭ НОМ

Театрын урлагийнхан хоёр шинэ бүтээлээ өлгийглөө



Тэртээ 1931 онд өрхөө татаж байсан "Бөмбөгөр ногоон" театрас урлагийн алтан үеийнхэн төрөн гарсан байдаг. Тэгвэл тэнд ажиллаж, Монголын урлагийн түүхийг босгосон уран бүтээлчдийн тухай өгүүлэх "Бөмбөгөр ногооны Мушгиа", "Алтан үе-Бөмбөгөр ногооныхон" гэсэн хоёр ч номын хуримтлал Театрын музейд боллоо.

Мэргэжлийн урлагийн байгууллагын үндэс суурь болсон тэрхүү театрын түүхийг хурин, алтан үеийн уран бүтээлч нөхдийн тухай ярих хүн хуруу дарам цөөн. Тэдний нэг нь найруулагч Б.Мушгиа юм. Түүний амьдрал, уран бүтээлийн замналыг өгүүлсэн "Бөмбөгөр ногооны Мушгиа" номыг "Зууны мэдээ" сонинны Ерөнхий эрхлэгч, сэтгүүлч Д.Отгонбаяр эмхэтгэжээ. Нээлтийн үеэр найруулагч Б.Мушгиа "Ном гэдэг хүний мөр, түүх юм. Энэ номыг бүтээж өгсөн уран бүтээлчиддээ баярлалаа. Мөн ном бүтээх шалтгаан болж буй театрын урлагтаа талархаж сууна" гэсэн юм. Дараагийн бүтээл болох "Алтан үе-Бөмбөгөр ногооныхон" номыг сэтгүүлч Н.Сарангэрэл, Ц.Энхмаа, түүхч С.Туяа нар эмхэтгэн гаргажээ. Мөн Л.Номингэрэл, Т.Чимгээ зэрэг таван эмэгтэй хамтран ажиллаж, энэ номыг уншигчийн гарт хүргэж буй аж.

Ийнхүү Б.Мушгиа найруулагчтай хамт ажиллаж байсан "Бөмбөгөр ногоон"-оор овоглодог ахмадууд, урлагийн үе үеийн төлөөлөл оролцож залуу нас, их урлагийн түүхээс хуучлан театрын урлагийнхан хоёр шинэ бүтээлээ өлгийдөн авлаа.



Гэрэл зургийг Г.АРТУУЖИЛН



СОНИРХУУЛАХАД

Төгөлдөр хуурч Ами: Би нулимсаа нуухгүй ээ

Ням гараг бүрийн үдэш цэнхэр дэлгэцийн өмнө монголчуудыг уяаж буй "Яг түүн шиг-2" шоуны шинэхэн дугаар үзэгчдэд хүрсэн. Улмаар "Эмоци" продакшны жүжигчин Б.Ариунцэцэг ялагч болж, гурван сая төгрөгийн эзэн болсон билээ. Гэвч, хаан хуур хөгжмөөсөө түр завсарлан мэргэжлийн дуучид, жүжигчдээс дутахааргүй авьяастай гэдгээ дугаар бүрт үзэгчиддээ харуулж буй төгөлдөр хуурч Ами сэтгэл дундуур үлдсэн бололтой. Тэрбээр шоуны сүүлийн дугаарт Эминемийн дүрийг эмэгтэй хүн гэхэд чадварлаг харуулснаар онлайн хэрэглэгчдийн дэмжлэгийг хүлээгээд байсан юм. Тэр хэрээр Амиг энэ удаагийн ялагч болно гэсэн хүлээлт үүсээд байв.

Харин шоуны оргил үе болох шүүгч, оролцогчид оноо өгөх мөчид ялалт жүжигчин Б.Ариунцэцэгт ирсэн нь сонгодог урлагийн бүсгүйд таалагдаагүй аж. Тэрбээр өөрийн фэйсбүүк хуудастаа "Ардын хүүхэд түрүүлж болдоггүй наадам уу гэдэг шиг Сонгодог урлагийн хүн түрүүлж болохгүй наадам юм шиг байна. Гурван оноо өгөх мөчид халуун сэтгэл рүү минь цэв хүйтэн ус цацах мэт мэдрэмж төрж суусныг би та бүгдээсээ нуухгүй ээ. Шударга зүйл гэж хаана байдаг юм бэр гэх асуулт хамгийн түрүүнд надад орж ирсэн. Би уг нь эхнээсээ л шударга байсан. Шоу бол шоу. Өрсөлдөөн бол өрсөлдөөн л юм байна даа. Энэ дугаарын дараа би нулимсаа нуухгүй ээ" хэмээн бичсэн байна.

ЗАРЛАЛ

ТЭМҮЖИН-ӨРЛӨГ ДҮНД СУРГУУЛЬ НЬ 2017-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫГ 2017ОНЫ 06-Р САРЫН 10-14 НИЙ ӨДРҮҮДЭД ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХ ИХ СУРГУУЛЬ ДЭЭР ЗОХИОН БАЙГУУЛНА

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛИЙГ Urlug.mndu.gov.mn

ХОЛБОГДОХ УТАС; 458673. 99052308